

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ “УЛААНБААТАР СПОРТ МЕНЕЖМЕНТ” ХК-ИЙН
2025 ОНД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2025.12.25

№	Хийгдэх ажил	Хугацаа	Гүйцэтгэл	Биелэлтийн хувь
Зорилт 1. Үйл ажиллагаа, зохион байгуулалтын алба				
ЭРХ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ ХҮРЭЭНД				
1.1	Засгийн газрын тогтоолын төсөл, бусад асуудалд удирдлагаас өгөх саналын төслийг боловсруулах, холбогдох нэгжээс боловсруулсан төсөлд санал өгөх;	2025.01.01- 2025.12.24	Тайлант хугацаанд Засгийн газрын тогтоолын төсөл, болон бусад асуудлаар санал аваагүй болно.	90%
1.2	Удирдлагаас гарах шийдвэрийн төсөл боловсруулах, холбогдох нэгжээс боловсруулсан төсөлд санал өгөх, хянах;	2025.01.01- 2025.12.24	Удирдлагаас гарах 8 тушаалын төслийг боловсруулж, 11 тушаалын төслийг хянаж ажилласан. Үйл ажиллагаатай холбоотой ажил гүйцэтгүүлэх чиглэлээр гүйцэтгэгч ААНБ-тай хийгдэж буй ажил гүйцэтгүүлэх тухай 3 гэрээний төслийг хянасан.	100%
1.3	Хүний нөөцийн буюу дотоод үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журмын төслийг хууль тогтоомжид нийцэж буй эсэхийг хянах, санал өгөх;	2025.01.01- 2025.12.24	Байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх Дотоод хяналтын журам, Ажилтны мэдээллийг авах, хадгалах, боловсруулах, ашиглах журам, Ажлын байранд хяналтын тоног төхөөрөмж ажиллуулах журмуудыг шинээр боловсруулж мөн Ёс зүйн дүрмийг шинэчлэн боловсруулж, ёс зүйн дэд хороог нийт ажилтны санал хураалтаар сонгон томилуулсан. Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулж, компанийн дүрэмд заасны дагуу ТУЗ-өөр хэлэлцүүлэн батлуулахаар бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна.	100%
1.4	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийн талаар холбогдох байгууллагатай хамтран сургалт зохион байгуулах;	2025.01.01- 2025.12.24	Байгууллагын нийт ажилтны хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, тухайн төрлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилчдын дунд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд асуулт хариултын АХА тэмцээн зохион байгуулах, тэмцээнээс гарсан үр дүнд тулгуурлан хууль нарийвчилсан зохицуулалт, урьдчилан сэргийлэх арга зам, анхаарах асуудлууд сэдвээр сургалт зохион байгуулахаар Гүйцэтгэх захирал	100%

			болон байгууллагын удирдлагуудад танилцуулж саналыг нэгтгэн ажиллаж байна.	
1.5	Компанийн холбогдох дүрэм, журмын хэрэгжилтийг хангах, мэдээлэл өгөх;	2025.01.01-2025.12.24	Шинээр батлагдсан дүрэм журмыг нийт ажилтанд танилцуулах, цаашид шинээр томилогдсон ажилтнуудад байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх дүрэм, журмыг танилцуулж, гарын үсгээр баталгаажуулах, шаардлагатай тохиолдолд сургалт зохион байгуулах талаар хөдөлмөрийн журамд зохицуулалт, заалтыг тусган оруулсан болно.	100%
ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААНЫ ХҮРЭЭНД				
1.2.1	Хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалт;	2025.01.01-2025.12.24	ТУЗ-ийн 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 09 тоот тогтоолоор "Бүтэц, орон тоо"-г шинэчлэн баталж, хүний нөөцийн бүрдүүлэлтийг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%
1.2.2	Байгууллагын албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангуулах;	2025.01.01-2025.12.24	Байгууллагын "Албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх 2025-2027 оны төлөвлөгөөг боловсруулж байна.	90%
1.2.3	Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах;	2025.01.01-2025.12.24	Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Нийт албан хаагчдын хүйсийн харьцаа эрэгтэй-55,5%, эмэгтэй-44,5%-ийг эзэлж байна.	-
1.2.4	Байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааг улирал бүр хийж, түүний мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулах;	2025.01.01-2025.12.24	2025 оны 8-р сард Соёлын судалгаанд Улаанбаатар спорт менежмент ХК компанийн 10 ажилтан оролцсон байна. Соёлын судалгааг McKinsey жишиг аргачлалын дагуу 10 чиглэлтийн 71 асуултаас бүрдсэн олон улсын түвшинд ашиглагддаг байгууллагын соёлын судалгааны асуулга аргачлалаар судалгааг авч боловсруулав. Компанийн хэмжээний байгууллагын соёлын үзүүлэлт 72.3% гэж гарсан байна.	-
1.2.5	Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, үйлчилгээг цахимжуулах чиглэлээр үр		Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, үйлчилгээг цахимжуулах чиглэлээр байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил	100%

	дүнтэй арга хэмжээ авч, байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, хүнд суртлыг багасгах, авлига үүсэх эрсдэлийг бууруулах;	2025.01.01-2025.12.24	тод байдлыг нэмэгдүүлж, хүнд суртлыг багасгах, авлига үүсэх эрсдэлийг бууруулах арга хэмжээний хүрээнд “Улаанбаатар спорт менежмент ХК” пэйж хуудсыг хөгжүүлэн мэдээллийг шилэн байдлаар ил тод хүргэн ажиллаж байна.	
1.2.6	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд хууль, зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэх, хариуг албан ёсоор өгч хэвших, өргөдөл, гомдлын хугацаа, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах, шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр тусгайлсан арга хэмжээ авч, хэрэгжилтийг хангаж ажиллах;	2025.01.01-2025.12.24	2025 онд албан тушаалтан, иргэнээс ирсэн 9 өргөдөл, хүсэлтийг холбогдох албан тушаалтанд танилцуулж дүрэм журам, хууль тогтоомжид нийцүүлэн арга хэмжээг авч ажилласан.	100%
1.2.7	Цалин хөлсний тухай журам боловсруулан батлуулах, хэрэгжүүлэх.	2025.01.01-2025.12.24	Гүйцэтгэх захирлын 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/09 тоот “Албан тушаалын цалин хөлсний хэмжээ тогтоох тухай” тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%
1.2.8	Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулах;	2025.01.01-2025.12.24	- Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулах санал асуулга явагдаж байна.	-
1.2.9	Ээлжийн амралтын төлөвлөгөөг боловсруулж, хууль эрхзүйн хүрээнд зохион байгуулах;	2025.01.01-2025.12.24	2026 оны “Ээлжийн амралтын хуваарь батлах тухай тушаалын төслийг боловсруулан бэлдэж байна.	-
1.2.10	2025 оны сургалт хөгжлийн төлөвлөлтийг боловсруулж, зохион байгуулах;	2025.01.01-2025.12.24	Нийт 8 албан хаагчийг Засгийн газрын худалдан авах ажиллагааны (А/3) сургалтад хамруулсан.	100%
1.2.11	Олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах;	2025.01.01-2025.12.24	Албан хаагчдын ажиллах идэвхийг өрнүүлэх, сэтгэл ханамжтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилготой олон нийтийн арга хэмжээг сар бүр зохион байгуулж ажилласан.	100%
АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ХҮРЭЭНД				
1.3.1	Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивд баримт хүлээж авах хуваарь, төлөвлөгөө гаргаж, ажилтнуудаас хугацаанд нь акт бүртгэлээр хүлээн авах;	2025.01.01-2025.12.24	2026 оны 1 дүгээр улиралд багтаан алба, нэгжүүдээс төлөвлөгөөт хуваарийн дагуу архивын баримт, бичгийг хүлээн авна.	

1.3.2	Архив, албан хэрэг хөтлөлтийн "Edoc" системийн шинэчлэгдсэн дүрэм, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах;	2025.01.01-2025.12.24	Архив, албан хэрэг хөтлөлтийн "Edoc" системийн шинэчлэгдсэн дүрэм, журмын хэрэгжилтийг хангаж харьяалагдах албанд зохих журмын дагуу ирсэн 68 бичгийг бүртгэн хуваарилж, зохих хугацаанд нь нийт 65 явуулсан бичгийг бүртгэн хүргүүлсэн.	100%
1.3.3	Байгууллагын ББНШК-ыг жилд 1-2 удаа хуралдуулж, байгууллагын хэмжээн дахь баримт бичгийн хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулалт шинэчлэн боловсруулах;	2025.01.01-2025.12.24	2026 оны хурлын товын бэлтгэлийг ханган ажиллаж байна.	100%
1.3.4	Архивын Улсын үзлэгийн бэлтгэл, зохион байгуулалтыг хангаж ажиллах;	2025.01.01-2025.12.24	Ажлын хэсэг гарган зохих хууль, дүрэм журмын дагуу бэлтгэл ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан.	100%

Зорилт 2. Санхүү, аж ахуйн алба

КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ХЭВИЙН ЖИГД, ТАСРАЛТГҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАЖ, ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, УДИРДЛАГЫГ САНХҮҮГИЙН ҮНЭН ЗӨВ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ ХҮРЭЭНД

2.1.1	Компанийн эдийн засаг, санхүүгийн үйл ажиллагааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын багц хуулиуд, Нийгмийн даатгалын багц хуулиуд, Аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, НББОУСтандарт зэрэг хууль тогтоомж, холбогдох заавар, журам, стандартын дагуу хэрэгжүүлэх, санхүүгийн хэвийн жигд, тасралтгүй үйл ажиллагааг хангах;	2025.01.01-2025.12.25	Компанийн 2025 оны тайлангийн гүйцэтгэл 1) Санхүүгийн тайланг хагас жилээр 1 удаа , 2) Хувь хүний орлогын албан татварын тайлан 3 удаа 3) Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлан 11 удаа 4) Аж ахуйн нэгжийн албан татварын тайлан хагас жилээр 1 удаа 5) Нийгмийн даатгалын тайлан 12 удаа 6) Шилэн дансны мэдээ 156 тайлан мэдээлэхээс, хугацаандаа оруулсан 138, хугацаа хоцорсон мэдээ 2 7) Shilengov.mn сайтад төсөв санхүү худалдан авах ажиллагааны талаарх мэдээ 4 удаа 8) Аудитын сайтад өмнөх жилийн аудитын зөвлөмжийн биелэлтийг улирал бүр хуулийн хугацаанд 4 удаа оруулан мэдээллсэн. Мөн биелэлтийг Нийслэл дэх төрийн аудит болон нийслэлийн дотоод аудит харьяа газруудад албан тоотоор 8 удаа хүргүүлсэн байна.	100%
-------	---	-----------------------	---	------

			9) Албанд 2025 оны тайлант хугацаанд https://erp.ulaanbaatar.mn/-системээр нийт ирсэн албан бичгийн тоо 35, явсан бичгийн тоо 30 10) Төсвийн гүйцэтгэлийн тайлан 11 удаа тус тус мэдээлэн ажилласан 11) Tender.gov.mn -д 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг оруулан гүйцэтгэлийг тухай бүрд мэдээллэсэн. Нийт 15 худалдан авалт төлөвлөснөөс: - Харьцуулалтын аргаар зарласан-1 - Шууд худалдан авалтын аргаар-14	
2.1.2		2025.01.01-2025.12.25	Нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу болон компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу бүртгэл хөтлөн ажилласан.Мөн үйл санхүүгийн үйл ажиллагаанд шаардлагатай 5 журам боловсруулан батлуулж мөрдөн ажиллаж байна.	100%
2.1.3		2025.05.01-2025.07.08	Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах төслийг боловсруулан Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн 2025 оны 07 сарын 08-ны өдрийн 25-94 тогтоолоор батлуулсан.	100%
2.1.4	Албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулах;	2025.11.01-2025.12.31	Компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн дугаар 09 тогтоолоор өөрчлөлт орсон бүтцийн дагуу Санхүү, аж ахуйн албаны ажилчдын албан тушаалын тодорхойлолтыг өөрчилж батлуулсан.	100%
КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ НЭГТГЭН БОЛОВСРУУЛАХ, БАТЛУУЛАХ, ШААРДЛАГАТАЙ ТОХИОЛДОЛД ТӨЛӨВЛӨГӨӨНД ЗОХИЦУУЛАЛТ ХИЙЖ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ АСУУДЛЫГ БОЛОВСРУУЛЖ ШИЙДВЭРЛҮҮЛЭХ, КОМПАНИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙГДЭХ АЛИВАА АСУУДАЛД САНАЛ ӨГӨХ ХҮРЭЭНД				
2.2.1	2025 оны үйл ажиллагааны төсөв батлуулах;	2025.01.01-2025.12.25	2025 оны үйл ажиллагааны төсвийг тайлант хугацаанд 3 удаа өөрчлөлт оруулан шинэчлэн батлуулсан. 1) Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн дугаар 04 2) Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн дугаар 10 3) Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дугаар 11 тус тус 3 удаа өөрчлөлт оруулан батлагдсан төсвийн хүрээнд Гүйцэтгэх захирлаар 2025 оны Худалдан авах	100%

			ажиллагааны төлөвлөгөөг 2 удаа өөрчлөлт оруулан батлуулсан. 4) 2025 онд албаны үйл ажиллагаатай хамааралтай А тушаал: 5) Эд хөрөнгө тооллогын тушаал 2 6) Тоног төхөөрөмж хөрөнгөд бүртгэх тухай 3 7) Хамтарсан тушаал 1 /Биеийн тамир спортын улсын хороо/ 8) Зардал гаргах тушаал 9 9) Тэтгэмж гаргах тушаал 5 10) Ур чадварын нэмэгдэл олгох журам 1 11) Албан тушаалын цалин хөлсний хэмжээ тогтоох 1 12) Унаа хоолны хөнгөлөлт шинэчлэн тогтоох 1 13) Аудитын зөвлөмжийн төлөвлөгөөг батлах 1 14) Үнэлгээний хороо байгуулах тушаал 1 нийт А тушаал 25, мөн Б тушаал нийт 44 гарч дээрх тушаалуудын хэрэгжилтийг ханган ажилласан.	
2.2.2	Батлагдсан төсвийн дагуу орлого, зарлагын гүйлгээг харилцах данс болон байгууллагын кассаар дамжуулан хүчин төгөлдөр анхан шатны баримтыг үндэслэн хийх, НББОУС-ын дагуу бүртгэлийг хөтлөх;	2025.01.01-2025.11.30	1) Нийт батлагдсан төсвийн дүн: 2,028,777,7.00 төгрөгөөс 2025 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар батлагдсан төсвийн гүйцэтгэлээр: 1,262,867.9 төгрөг: 2) Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд: 979,220.10 төгрөг төсөвлөснөөс 656,040.94 төгрөг зарцуулсан. 3) Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл: 122,402 төгрөгөөс 76,688 төгрөг 4) Байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд: 243,967.20 төгрөгөөс 229,562.07 төгрөг, 5) Хангамж, бараа материалын зардалд: 37,140.0 төгрөгөөс 25,102.2 төгрөг, 6) Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж: 585,048.0 төгрөгөөс 233,734.06 төгрөг, 7) Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал: 39,000.00 төгрөг 41,740.90 төгрөг тус бүрд зарцуулан ажилсан байна. Үүнийг хувьчилж үзвэл: Батлагдсан төсвөөс гүйцэтгэл 62.3 хувьтай байна. Үүнд:	90%

			- Цалин хөлс болон нэмэгдэл урамшил 32.4 хувь, - Ажил олгогчоос олгох НДШ 3.8 хувь, - Байр ашиглалтай холбоотой зардал 11.3 хувь, - Хангамж, бараа материалын зардал 1.24 хувь, - Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 11.5 хувь, - Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал 2.1 хувь тус тус эзэлж байна.	
2.2.3	Бэлэн мөнгөний гүйлгээ гарсан тухай бүр кассын орлого, зарлагын ордер үйлдэх, эдгээр баримтуудыг санхүүгийн программд бүртгэх, кассын тайланг сараар гарган баталгаажуулж, тайлагнах;	2025.01.01-2025.11.30	1. Бэлэн мөнгөний тайланг 12 удаа гаргахаас 11 удаа гаргаж хянуулан бүртгэл хөтөлсөн.Тус тайлангийн гүйцэтгэл: ✓ Орлого: 20,000.00 төгрөг ✓ Зарлага: 19,260.58 төгрөг Үүнд: Шатахуун - 310.00 Тээврийн зардал -165.00 Хангамжийн зүйлс -9,458.26 Цэвэрлэгээ үйлчилгээ -3,272.90 Засвар үйлчилгээ -1,9300.15 тус тус зарцуулсан байна. 2. Бараа материалын тайлан 12 удаа гаргаж тайлагнахаас – 11 удаа 3. Шатахууны тайлан 12 –11 удаа 4. Үндсэн хөрөнгийн тайлан хагас бүтэн жилээр 2 удаа гарган бүртгэл хөтлөн тайлагнасан.	90%
АЛБАНЫ ӨДӨР ТУТМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, АЛБАН ХААГЧДЫГ АРГА ЗҮЙН УДИРДЛАГААР ХАНГАХ, АЖИЛД ХЯНАЛТ ТАВИХ, ҮНЭЛЭХ, ҮР ДҮНГ ТООЦОН АЖИЛЛАХ				
2.3.1	Албаны дотоод арга хэмжээ, чиг үүргийг хэрэгжүүлэх;	2025.01.01-2025.12.25	Үйл ажиллагааны хүрээнд албан хаагч тус бүр ажлын чиг үүргийн дагуу хийгдсэн ажлын тайланг сар бүрийн 25-ний өдрийн дотор гарган хянуулан дүгнүүлдэг. Албаны бүтэц орон тооны гүйцэтгэл 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 71%-тай байна.	100%

2.3.2	Албан хэрэг хөтлөлтийн стандартыг хэрэгжүүлж чиг үүрэгт хамраах, мэдээ, мэдээлэл, тайлан холбогдох материалыг "Компанийн хөтлөх хэргийн жагсаалт"-ын дагуу архивын нэгж болгон хүлээлгэж өгөхөд дэмжлэг үзүүлэх;	2025.01.01- 2025.12.25	Архивын улсын үзлэгт, шалгалтын хүрээнд компаниас гаргасан ажлын хэсгийн төлөвлөгөөний хүрээнд албаны бүх ажилчид хамтран оролцож ажилласан.	90%
2.3.3	Хариуцсан ажлын чиглэлээр мэдлэг мэргэжлээ байнга дээшлүүлж, санал санаачлага гарган үр бүтээлтэй ажиллах, гадаад хэлний мэдлэг, ур чадвараа нэмэгдүүлэх;	2025.01.01- 2025.12.25	1) Албаны санхүүгийн үйл ажиллагааны хүрээнд татварын зөвлөх үйлчилгээг Татварын мэргэшсэн зөвлөх С.Баярхүү /Магистр, МНБ, ТМЗ/ Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлан болон данс бүртгэлтэй холбоотой сургалтад санхүүгийн менежер Н.Эрдэнэханд, ерөнхий нягтлан бодогч Б.Нэмжбадгар суусан. 2) Нийслэлийн өмчийн харилцааны газраас зохион байгуулсан “Өмчийн цахим программ шинэчлэлтэй холбоотой сургалтад 2025 оны 10 дугаар сарын 18-ний өдөр Б.Бямбажав хамрагдсан. 3) Санхүүгийн менежер Н.Эрдэнэханд Татварын мэргэшсэн зөвлөхийн эрх олгох сургалтад хамрагдан 1 дүгээр шатны эрхээ авсан. 4) Ерөнхий нягтлан бодогч Б.Нэмжбадгар Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх сунгах хүрээнд 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдөр эрхээ авсан	100%
2.3.4	Албаны эрхэлсэн асуудал, чиг үүргийн хүрээнд компанийг төлөөлж холбогдох төрийн байгууллага болон бусад гадаад дотоодын байгууллага, хуулийн этгээдийн өмнө компанийг төлөөлж ажиллана;	2025.01.01- 2025.12.25	1) 2025.01.03-ны өдрөөс байгууллагад Нийслэлийн дотоод хяналтын шалгалт орж 2019-2024 он хүртэлх санхүүгийн шаардлагатай баримт материалыг бэлдэж шалгалтын комиссын гишүүдэд хүлээлгэн өгсөн. 2) 2024 оны жилийн эцсийн санхүүгийн баримтыг “Дунд манхайдай” нийслэл дэх төрийн аудитын газар хүлээлгэн өгсөн. 3) Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/33 захирамжийн дагуу Агаар бохирдуулагч эх үүсвэрийн судалгаа гаргах хяналт шалгалтын хүрээнд 2025.01.18.19- ний өдөр Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 7-р хорооны 9-р дэвсгэрт албаны хүмүүстэй хяналт шалгалт хийж хамтран ажилласан.	100%

			4) АТГ-т шалгагдаж байсан санхүүгийн баримтуудыг актын дагуу хүлээн авсан. 5) Жудо бөхийн Залуучуудын аварга шалгаруулах тэмцээнд Зөдөр татами, хөл лед дэлгэц түрээслүүлж хамтран ажилласан. 6) УБСМ ХК-ийн ТУЗ-ын 2025 оны эхний хуралд шаардлагатай материал бүрдүүлж хамтран ажилласан. 7) Нийслэлээс зохион байгуулсан бүх нийтийн цэвэрлэгээ болон мод тарих арга хэмжээнд 8) 2019-2024 оны нэгдсэн архивын ажилд хамтран ажиллаж, архивын хадгалах хугацаа нь дууссан баримтуудыг холбогдох журам стандартын дагуу ангилан ялгаж, устгалд оруулах бэлтгэлд хамтран ажилласан. 9) 2025 оны хагас жилийн санхүүгийн баримтыг “Ай Жэй Эй Эйч” нийслэл дэх төрийн аудитын газар хүлээлгэн өгсөн.	
УДИРДЛАГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫГ ЦАГ ХУГАЦААНД НЬ ЧАНАРТАЙ САЙН БИЕЛҮҮЛЖ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮНГ ТОГТМОЛ ТАЙЛАГНАХ				
2.4.1	Удирдлага болон хариуцсан ажлын хүрээнд санаачилгатай, ажлын бүтээмж, ажлын цаг ашиглалтыг нэмэгдүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж, үр дүнтэй ажилласан байна;	2025.01.01-2025.12.25	1. 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Биеийн тамир, спортын улсын хорооны дарга, Улаанбаатар спорт менежмент ХК-ийн гүйцэтгэх захирлын хамтарсан тушаалаар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, биеийн тамир, спортын газрын төсөвт “Олон Улсын залуучуудын наадам”-ын бэлтгэл ажлын зардал, 2020 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн санхүүжилтийн гэрээний дагуу үлдэгдэл өглөг, авлага барагдуулах хоёр талын оролцоо бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн байгуулагдаж дараах гэрээгээр нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийг тоолно. Үүнд: ✓ БЗ/20-04 дугаартай “Усан бассейн автомат цаг нийлүүлэлт суурилуулалт”-ын гэрээгээр нийлүүлсэн тоног төхөөрөмж ✓ БЗ/20-05 дугаартай “Спорт цогцолборын фитнес заалны тоног төхөөрөмж нийлүүлэлт суурилуулалт”-ын гэрээгээр нийлүүлсэн тоног төхөөрөмж	100%

			✓ Б3/20-06-1 дугаартай “Спорт цогцолборын спортын заалны шал нийлүүлэлт суурилуулалт”-ын гэрээгээр нийлүүлсэн тоног төхөөрөмж ✓ Б3/20-07 дугаартай “Спорт цогцолборын спортын заалны үзэгчдийн суудал нийлүүлэлт, суурилуулалт”-ын гэрээгээр нийлүүлсэн тоног төхөөрөмжүүдийг тоолж, өглөг авлагын тооцоог барагдуулах ажилд хамтран ажиллаж, Буянт-Ухаа агуулахад хүлээн авсан. ✓ Монголын волейболын холбооноос зохион байгуулж буй Монголын волейболын холбооны хөгжлийн лигийн тэмцээнд /Волейболын шал, сетик, антин/ волейболын шал нийлүүлэн хамтран ажилласан. 2. Хөрөнгийн бүртгэлийг гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан тооллогын комиссын бүрэлдэхүүн, Ай Жэй Эй Эйч Аудитын ажилтантай хамтран жилийн эцсийн тооллого хийсэн.	
Зорилт 3. Барилга захиалагчийн ажлын алба				
3.1	Нийслэлийн хяналт шалгалтын газраас барилгад үзлэг шалгалт хийлгэх, улсын байцаагчийн дүгнэлт гаргуулах;	2025.06.04-2025.12.24	Цэнгэлдэх хүрээлэн, спорт цогцолборын спортын төвийн барилгын угсралтын ажлын тухай” 2025.09.30-ны өдрийн 02-13-01/026/389 дугаартай; “Цэнгэлдэх хүрээлэн, спорт цогцолборын спортын төвийн В болон С блокийн барилгын хүчитгэлийн ажлын тухай” 2025.11.04-ний өдрийн 02-13-01/026/438 дугаартай Нийслэлийн хяналт шалгалтын газрын Улсын ахлах байцаагч (Ц.Алтансүх)-ийн дүгнэлт гарсан.	100%
3.2	Барилгын ажлыг үргэлжлүүлэхэд шаардлагатай зөвлөхийн үйлчилгээ авах;	2025.06.04-2025.12.24	Барилгын бүтээцийн зураг төсөл боловсруулахад зөвлөх, барилгын талбай дээр хийгдсэн бодит ажлууд болон буулгах, хүчитгэх ажлын тоо хэмжээг гаргах комисст ажиллах, тендерийн бичиг баримт бүрдүүлэхэд туслах үүрэг бүхий Зөвлөх үйлчилгээний гэрээг Монгол улсын зөвлөх инженер Н.Гэрэлтцолмонтой байгуулан 2025.09.26-ны өдрөөс эхлэн хамтран ажиллаж байна. Үйлчилгээний ажлын тайланг сар бүр авч ажилласан.	100%

3.3	“Цэнгэлдэх хүрээлэн, спорт цогцолбор”-ын спортын төвийн барилгын талбай дээр хийгдсэн бодит ажлууд болон хүчитгэх, буулгах ажлын тоо хэмжээг гаргах;	2025.06.04-2025.12.24	Нийслэлийн Засаг даргын 2025 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/1354 дугаар захирамжаар “Цэнгэлдэх хүрээлэн, спорт цогцолбор”-ын спортын төвийн барилгын талбай дээр хийгдсэн бодит ажлууд болон буулгах, хүчитгэх ажлын тоо хэмжээг гаргах үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллаж үр дүнг 2025.11.04-ний өдөр НЗД-ын Тамгын газрын дарга Д.Амгаланд танилцуулсан.	100%
3.4	Геозидийн хяналтын хэмжилт хийлгэх;	2025.06.04-2025.12.24	“Баясах сурвэй” ХХК-ийн 2025.10.17-ны өдрийн “Цэнгэлдэх хүрээлэн, спорт цогцолбор”-ын барилгын металл багануудад эгц босоогийн хяналтын хэмжилтийн дүгнэлт гарсан.	100%
3.5	“Цэнгэлдэх хүрээлэн, спорт цогцолбор”-ын спортын төвийн барилгын төслийн В, С блокийн хүчитгэлийн зураг төсөл боловсруулах;	2025.06.04-2025.12.24	“Цэнгэлдэх хүрээлэн, спорт цогцолбор”-ын барилгын В, С блокийн засвар, хүчитгэлийн ажлын зургийг “Архидеа” ХХК-р боловсруулан Барилга хөгжлийн төвийн 2025.11.18-ны өдрийн 2140/2025 дугаартай магадлалын дүгнэлт гарсан.	100%
3.6	“Цэнгэлдэх хүрээлэн, спорт цогцолбор”-ын спортын төвийн барилгын ажлын А блокийн хучилтын зураг төсөл дахин боловсруулах;	2025.06.04-2025.12.24	“Цэнгэлдэх хүрээлэн, спорт цогцолбор”-ын спортын төвийн барилгын ажлын А блокийн хучилтын зураг төслийг дахин боловсруулах үйлчилгээг “Хаус констракшн” ХХК-иар гүйцэтгүүлж, зургийн ажил дуусаж, магадлалаар орж байна.	90%
3.7	“Цэнгэлдэх хүрээлэн, спорт цогцолбор”-ын барилгын хэв гажилтын дүгнэлт гаргуулах;	2025.06.04-2025.12.24	“Цэнгэлдэх хүрээлэн, спорт цогцолбор”-ын барилгын хэв гажилтын дүгнэлт гаргуулахаар ШУТИС-ийн Барилга, Архитектурын сургуулийн Оношилгоо зураг төсөл, судалгааны “Реконстракшн” төвтэй 2025.11.13-ны өдрөөс эхлэн хамтран ажиллаж, ажлын гүйцэтгэл 90 хувьтай явагдаж байна.	90%
Зорилт 4. Спорт менежментийн алба				
4.1	Спортын секц, клубүүдийн мэдээллийн сайт хөгжүүлэх;	2025.06.04-2025.12.24	usm.mn сайтын шинэчлэлийг хийсэн “Промакс” ХХЗ-аар https://usm.mn/sport-clubs булан хөгжүүлэлтийн ажлыг Ажил гүйцэтгэх гэрээний дагуу гүйцэтгүүлэв. Мөн тус байгууллагаас нийт албан хаагчдын дунд сайтын админ хийх сургалт зохион байгуулав.	100%
4.2	Секц, клубүүдийн мэдээллийг цуглуулах;	2025.06.04-2025.12.24	usm.mn/sport-clubs сайтын хөгжүүлэлтийн хүрээнд секц, клубүүдийн мэдээлэл цуглуулж, боловсруулж, байршуулах ажлыг “Нэгура солюшнс” ХХК-тай гэрээ байгуулж гүйцэтгүүлэв. Нийт спортын 30 төрлийн 130	100%

			сургалтын мэдээллийг утсаар, сошиал хуудсаар, google формоор цуглуулав.	
4.3	Секц, клубүүдийн мэдээллийг боловсруулж, вэбсайтад байршуулах;	2025.06.04-2025.12.24	“Нэгура солюшнс” ХХК-тай спортын сургалтын газруудын мэдээллийг нягтлаж, боловсруулан usm.mn/sport-clubs сайтад байршуулах ажлыг гүйцэтгэв. Нийт 130 сургалтын мэдээллийг байршуулав.	100%
4.4	Жүдогийн татамиг Улаанбаатарын Гранд слам тэмцээнд ашиглуулах;	2025.06.04-2025.12.24	Монголын Жүдогийн холбоотой жүдогийн татами ашиглуулах гэрээ байгуулж ажиллав. 2025 оны 07 дугаар сарын 25-27-ны хооронд Степпе аренад зохион байгуулагдсан ОУЖБХ-ны Гран-При тэмцээнд жүдогийн татами ашиглуулах гэрээ хийж ажиллав.	100%
4.5	Волейболын хэрэглэлийг МВХ-ны лигийн тэмцээнд ашиглуулах гэрээ байгуулах;	2025.06.04-2025.12.24	Монголын Волейболын холбооны хөгжлийн лигийн тэмцээний түнш байгууллагаар “Улаанбаатар спорт менежмент” ХК ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд волейболын иж бүрэн хэрэглэлийг Хөгжлийн лигийн тэмцээнд ашиглуулах гэрээ хийж, хяналт тавин ажиллаж байна.	100%
4.6	Төсөл хэрэгжүүлэх боломжтой байгууллагуудтай уулзалт хийх;	2025.06.04-2025.12.24	Спортын төсөл хөтөлбөрийн судалгаа хийх зорилгоор спортын байгууллагатай уулзалт хийв. 2025 оны 08 дугаар сараас 12-р сарын хооронд нийт 7 байгууллагын удирдлага, 1 хувь хүнтэй уулзалт зохион байгуулж, төсөл хөтөлбөр хамтран хэрэгжүүлэх боломжийн тухай хэлэлцэв.	100%
4.7	Төслийн хамрах хүрээ, санхүүгийн үр ашгийн тооцоо гаргах;	2025.06.04-2025.12.24	Нийслэлийн өмчит ХК хэрэгжүүлэх боломжтой байж болох төсөл хөтөлбөрийн жагсаалт гаргаж, санхүүгийн үр ашгийн тооцооллыг хийв. Судалсан төслүүд цаг хугацаа болон мэргэжлийн боловсон хүчин шаардах тул үргэлжлүүлэх нөхцөлийг хангахгүй байна гэж үзсэн болно.	100%
4.8	НБТСГ-аас нийслэлийн хэмжээнд хэрэгжиж буй арга хэмжээний мэдээллийг авч, үйл ажиллагааны төлөвлөлтөд тусгах;	2025.06.04-2025.12.24	Нийслэлийн Биеийн тамир, спортын газартай уулзалт зохион байгуулж, Нийслэлд хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл авав. Компанийн удирдлагад НБТСГ-ын хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээллийг хүргэж, цаашид иргэдэд хүртээмжтэй, олон нийтийн оролцоог хангасан арга хэмжээг судлах чиглэл гаргасан болно.	100%

4.9	Олон нийтийн оролцоог хангах төсөл хөтөлбөрийн боловсруулах;	2025.06.04-2025.12.24	Олон нийтийн оролцоог хангах төсөл, хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд Нийслэлийн дүүргүүдэд бүх насны иргэдийн дунд Гудамжны спортын сонирхогчдын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах боломжийг судалж байна. Дүүргүүдийн спортын хороодод гадаа талбай, дэд бүтцийн байдлын тухай мэдээлэл авах, хамтран ажиллах тухай хүсэлт илгээсэн.	45%
4.10	Томоохон спорт цогцолборуудын судалгаа хийх;	2025.06.04-2025.12.24	Степпе арена, М арена /UG арена/-ийн хүчин чадал, багтаамж, үйлчилгээний судалгаа хийв.	90%
4.11	Спорт цогцолборын зах зээлийн боломж, хэрэгцээ шаардлагын судалгааны даалгавар боловсруулах;	2025.06.04-2025.12.24	ХУД-ын 8-р хорооны нутаг дэвсгэрт хэрэгжиж буй Спорт цогцолборын хэрэгцээ, шаардлага, зах зээлийн боломжийг тодорхойлох судалгааны даалгаврыг боловсруулав.	90%
4.12	Спортын цогцолборын бүтээн байгуулалтын талбайд хийгдэх зочид буудлын зах зээлийн судалгааны даалгавар боловсруулах;	2025.06.04-2025.12.24	ХУД-ын 8-р хороонд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх зочид буудлын төслийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, боломжийн тухай судалгааны даалгавар боловсруулав.	90%